



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/235

Номгон

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын
зэрэгт шилжсэн үед авч хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/215, А/221 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 34 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын тохиолдол тус аймагт нэмж бүртгэгдэж, эх үүсвэрүүдийн хавьтлуудыг тогтоохын тулд тандалт судалгааг зохион байгуулах, цаашид тархалтыг зогсоох зорилгоор гэрийн тусгаарлалт, ажиглалтад тавих хяналтыг чангатгаж, 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 24.00 цаг хүртэл гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж, аймгийн хэмжээнд явган хүн болон авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоож, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй. Үүнд:

1.1. Дээрх хугацаанд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, ус усан хангамж түгээх цэгүүд, эрчим хүч, хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, барилга, барилгын материалын дэлгүүр, шатахуун түгээх станцууд нэгдсэн ариутгал, халдваргүйжүүлэлтийг нэгдсэн хэлбэрээр иж бүрэн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэхийг холбогдох байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт;

1.2. Гэрийн тусгаарлалт, ажиглалтад тавих хяналтыг чангатгаж, Онцгой комиссын гишүүдийг хуваарь гарган, хяналт тавьж ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, (хурандаа Г.Нэмэхбаяр)-д;

1.3. Ойрын болон дам хавьтлуудын хяналтыг чангатгаж, аймгийн Онцгой комиссын гишүүдийн оролцоотойгоор нэгдсэн хяналт, шалгалтыг зохион

1210587


байгуулан, тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн сахилга, хариуцлагыг сайжруулж ажиллахыг Тагнуулын хэлтсийн дарга, (дэд хурандаа Р.Мэндбаяр)-г;

1.4.Дээрх хугацаанд коронавируст халдварын тандалт судалгааг хийж, дам хавьтал бүхий иргэдээс шинжилгээ авах ажлыг Эрүүл мэндийн газрын дарга, (Н.Энхжаргал)-д;

1.5.Аймгийн хэмжээнд нэгдсэн ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг хуваарь, төлөвлөгөө гарган зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-т тус тус үүрэг болгосугай.

2.Явган хүн хүн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоосонтой холбогдуулан эргүүл, жижүүрт үүрэг гүйцэтгэх иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих байгууллагуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН